



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 5/03

Мандалговь

Т.Саранчимэгийг шилжүүлэн
томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.3 дэх хэсгүүд, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 10 дугаар зүйлийн 10.7 дэх хэсэг, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, “Журам батлах тухай” 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 6 дугаар хавсралтууд, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын 3.1 дэх хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дэх хэсгүүд, “Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай” аймгийн Засаг даргын 2024 оны А/04 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өлзийт сумын газрын даамал Төмөрийн Саранчимэгийн 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн өргөдөл, “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” Авлигатай тэмцэх газрын 2024 оны 05/777 тоот албан бичиг, “Т.Саранчимэгийг шилжүүлэн ажиллуулах тухай” Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны Б/01 дүгээр тушаалын дагуу тус Газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.

2.Т.Саранчимэгийн албан тушаалын үндсэн цалинг Т3-7 буюу 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 12 хувиар, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг 20 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 30 хувиар, хоолны үнийн хөнгөлөлтийг өдрийн 4,000 (дөрвөн мянга) төгрөгөөр тус тус тогтоож, томилогдсон өдрөөс эхлэн хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг ерөнхий нягтлан бодогч (А.Нэргүй)-д зөвшөөрсүгэй.

Tushaal B.docx

482401007

3.Байгаль орчны хяналтын улсын байцаагч Төмөрийн Саранчимэгийг байгууллагын дүрэм, журам, бичиг баримтуудтай танилцуулан, Төрийн албан хаагчийн хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүрдүүлэн хүний нөөцийн системд албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батхүү)-д даалгасугай.

4.Холбогдох хууль, тогтоомж, газрын дүрэм, журмуудыг чанд сахин, гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан, идэвх зүтгэл гарган, хариуцсан ажлаа чанартай гүйцэтгэж ажиллахыг (Т.Саранчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА

